



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2026/011/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Говьсүмбэр аймаг 2026 он</p>	<p>Дарга тэргүүлэх аудитор: Утас: 7054-3156 Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govissumber@audit.gov.mn

2026.02.25 № 10
танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ЗАХИРЛЫН
ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.МЯГМАРСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4226050062

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 101 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээгээр 81.0 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>780,437,644.81</u>	<u>993,219,938.13</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	299,868,890.74	376,850,523.83
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	299,868,890.74	376,850,523.83
3121	Төгрөг	299,868,890.74	376,850,523.83
31211	Төрийн сангийн харилцах	259,541,979.74	376,850,523.83
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	40,326,911.00	-
33	АВЛАГА	7,460,688.28	37,940,938.51
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,180,687.63	407,362.81
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	6,280,000.00	6,280,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	27,426,911.00
335	Бусад авлага	0.65	3,826,664.70
3351	Байгууллагаас авах авлага	-	3,826,664.05
3352	Хувь хүмүүсээс авах авлага	0.65	0.65
34	УРЬДЧИЛГАА	5,879,179.00	5,879,179.00
3471	Урьдчилгаа тооцоо	5,879,179.00	5,879,179.00
34713	Цалингийн урьдчилгаа	5,879,179.00	5,879,179.00
35	БАРАА МАТЕРИАЛ	467,228,886.79	572,549,296.79
354	Хангамжийн материал	467,228,886.79	572,549,296.79
35420	Аж ахуйн материал	457,017,276.78	565,192,096.78
35460	Хүнсний материал	10,211,610.01	7,357,200.01
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,541,835,116.73</u>	<u>4,607,477,822.43</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,541,835,116.73	4,607,477,822.43
392	Биет хөрөнгө	4,333,899,116.73	4,399,541,822.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,898,012,275.23	3,898,012,275.23
39202	Хуримтлагдсан элэгдэл	(712,646,854.56)	(831,421,330.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	71,502,075.00	71,502,075.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(71,502,075.00)	(71,502,075.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,261,088,906.26	1,707,940,610.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,365,453,789.93)	(625,189,017.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	575,305,761.00	460,219,015.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(383,562,319.14)	(273,312,318.40)
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(13,166,666.93)	(15,166,666.97)
39217	Ном	54,321,804.80	58,459,254.80
393	Биет бус хөрөнгө	207,936,000.00	207,936,000.00
39301	Програм хангамж	9,090,995.00	9,090,995.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(9,090,995.00)	(9,090,995.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	209,886,000.00	209,886,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,950,000.00)	(1,950,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,322,272,761.54</u>	<u>5,600,697,760.56</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>15,323,998.83</u>	-

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,323,998.83	-
413	Өглөг	15,323,998.83	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	15,310,628.38	-
4136	Бусад өглөг	13,370.45	-
41361	Байгууллагад төлөх өглөг	13,370.45	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,306,948,762.71	5,600,697,760.56
51	Засгийн газрын хувь оролцоо	5,306,948,762.71	5,600,697,760.56
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,681,905,393.60	3,681,905,393.60
512	Хуримтлагдсан үр дүн	873,043,605.42	1,166,792,603.27
51210	Өмнөх үеийн үр дүн	-277,970,254.31	873,043,605.42
51220	Тайлант үеийн үр дүн	1,151,013,859.93	293,748,997.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	751,999,763.69	751,999,763.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,322,272,761.54	5,600,697,760.56

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,251,164,700.06	5,357,453,677.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,060,192,000.06	506,582,347.40
120	Нийтлэг татварын бус орлого	1,060,192,000.06	506,582,347.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	42,627,000.00	506,582,347.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,627,000.00	37,805,100.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	00.00	386,568,727.40
120005	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал	00.00	82,208,520.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,190,972,700.00	4,850,871,330.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,537,472,700.00	4,085,871,330.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,537,472,700.00	4,085,871,330.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	547,440,000.00	765,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	547,440,000.00	765,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,100,150,840.13	5,063,704,679.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,100,150,840.13	5,063,704,679.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,874,847,131.60	4,869,599,483.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,313,234,464.43	2,876,111,170.76
210101	Үндсэн цалин	1,497,621,807.70	1,637,077,511.07
210102	Нэмэгдэл	629,805,647.73	987,889,519.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	64,110,000.00	109,742,000.00
210104	Урамшуулал	121,697,009.00	141,402,140.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	283,569,264.30	351,568,084.65
210201	Тэтгэврийн даатгал	195,768,348.66	241,867,055.36
210202	Тэтгэмжийн даатгал	23,167,100.80	28,744,605.22

210203	ҮОМШӨ-ний даатгал	12,115,191.58	14,887,961.82
210204	Ажилгүйдлийн даатгал	10,799,834.98	13,121,316.49
210205	Эрүүл мэндийн даатгал	41,718,788.28	52,947,145.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	646,232,258.69	695,086,499.60
210301	Гэрэл, цахилгаан	40,788,625.81	55,106,643.36
210302	Түлш, халаалт	528,991,886.92	565,551,006.24
210303	Цэвэр, бохир ус	76,451,745.96	74,428,850.00
2104	Хангамж, бараа материалын зардал	85,608,657.60	65,444,902.00
210401	Бичиг хэрэг	28,605,700.00	35,591,500.00
210402	Тээвэр, шатахуун	10,800,379.00	9,419,607.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	27,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	46,175,578.60	20,433,795.00
2105	Нормативт зардал	113,610,090.00	202,916,590.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,468,510.00	2,337,710.00
210502	Хоол, хүнс	110,141,580.00	200,578,880.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	99,811,011.00	171,827,845.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,308,300.00	3,198,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,318,500.00	6,735,760.00
210604	Урсгал засвар	91,184,211.00	161,893,485.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	332,781,385.58	506,644,391.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,634,635.78	43,817,982.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	60,195,775.00	91,313,338.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	223,950,974.80	371,513,071.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	225,303,708.53	194,105,195.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	224,035,967.22	143,911,695.44
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	53,405,967.22	69,377,695.44
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	162,245,000.00	74,534,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,385,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,267,741.31	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	50,193,500.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	50,193,500.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,151,013,859.93</u>	<u>293,748,997.85</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,151,013,859.93</u>	<u>293,748,997.85</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>4,273,130,340.00</u>	<u>4,889,217,324.52</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>82,157,640.00</u>	<u>38,345,994.52</u>
120	Нийтлэг татварын бус орлого	<u>82,157,640.00</u>	<u>38,345,994.52</u>

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	82,157,640.00	38,345,994.52
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,707,000.00	38,345,994.52
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,450,640.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,190,972,700.00	4,850,871,330.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,537,472,700.00	4,085,871,330.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,537,472,700.00	4,085,871,330.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	653,500,000.00	765,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	653,500,000.00	765,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,983,177,720.26	4,761,648,641.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,983,177,720.26	4,761,648,641.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,757,874,011.73	4,540,116,534.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,336,352,591.81	2,899,195,236.88
210101	Үндсэн цалин	1,416,990,178.74	1,659,474,065.61
210102	Нэмэгдэл	707,877,079.18	990,629,807.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	90,120,873.67	109,371,252.67
210104	Урамшуулал	121,364,460.22	139,720,111.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	284,767,571.85	347,402,251.11
210201	Тэтгэврийн даатгал	190,821,493.56	238,155,631.95
210202	Тэтгэмжийн даатгал	23,583,580.87	28,155,116.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,870,641.40	14,372,561.37
210204	Ажилгүйдлийн даатгал	11,694,430.14	13,277,941.93
210205	Эрүүл мэндийн даатгал	46,797,425.88	53,440,999.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	646,232,258.69	695,086,499.60
210301	Гэрэл, цахилгаан	40,788,625.81	55,106,643.36
210302	Түлш, халаалт	528,991,886.92	565,551,006.24
210303	Цэвэр, бохир ус	76,451,745.96	74,428,850.00
2105	Нормативт зардал	114,510,750.00	197,724,470.00
210502	Хоол, хүнс	114,510,750.00	197,724,470.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,240,700.00	23,862,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,253,100.00	4,142,000.00
210604	Урсгал засвар	15,987,600.00	19,720,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	24,150,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	24,150,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	351,770,139.38	352,695,277.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	185,480,789.38	161,829,954.52
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	166,289,350.00	190,865,322.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	225,303,708.53	221,532,106.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	224,035,967.22	143,911,695.44
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	53,405,967.22	69,377,695.44
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	162,245,000.00	74,534,000.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,385,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	27,426,911.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	27,426,911.00
213304	Хөрөнгийн	00.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,267,741.31	50,193,500.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,267,741.31	50,193,500.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>289,952,619.74</u>	<u>127,568,683.09</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	610,000.00	50,587,050.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	610,000.00	50,587,050.00
2200	Дотоод эх үүсвэрээр	610,000.00	50,587,050.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	610,000.00	50,587,050.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-610,000.00</u>	<u>-50,587,050.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	289,342,619.74	76,981,633.09
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,526,271.00	299,868,890.74
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	299,868,890.74	376,850,523.83

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	3,681,905,393.60	751,999,763.69	-277,970,254.51	00.00	4,155,934,902.78
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,681,905,393.60	751,999,763.69	-277,970,254.51	00.00	4,155,934,902.78
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,151,013,859.93	00.00	1,151,013,859.93
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,681,905,393.60	751,999,763.69	873,043,605.42	00.00	5,306,948,762.71
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	3,681,905,393.60	751,999,763.69	873,043,605.42	00.00	5,306,948,762.71
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,681,905,393.60	751,999,763.69	873,043,605.42	00.00	5,306,948,762.71
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	293,748,997.85	00.00	293,748,997.85
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,681,905,393.60	751,999,763.69	1,166,792,603.27	00.00	5,600,697,760.56

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		259,541,979.7
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,203,186,700.0	4,006,908,780.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,203,186,700.0	4,006,908,780.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,059,207,400.0	3,862,997,085.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,921,958,500.0	2,899,195,236.9
210101	Үндсэн цалин	1,858,072,900.0	1,659,474,065.6
210102	Нэмэгдэл	948,920,500.0	990,629,807.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	114,965,100.0	109,371,252.7
210104	Урамшуулал	0	139,720,111.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	372,418,100.0	347,402,251.1
210201	Тэтгэврийн даатгал	253,244,300.0	238,155,632.0
210202	Тэтгэмжийн даатгал	29,793,400.0	28,155,116.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,896,800.0	14,372,561.4
210204	Ажилгүйдлийн даатгал	14,896,800.0	13,277,941.9
210205	Эрүүл мэндийн даатгал	59,586,800.0	53,440,999.8
2105	Нормативт зардал	289,069,000.0	197,724,470.0
210502	Хоол, хүнс	289,069,000.0	197,724,470.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,757,100.0	4,142,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	16,757,100.0	4,142,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	62,686,000.0	56,150,400.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,686,000.0	56,150,400.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	396,318,700.0	358,382,727.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	194,365,800.0	169,329,904.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	201,952,900.0	189,052,822.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	143,979,300.0	143,911,695.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	143,979,300.0	143,911,695.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	69,445,300.0	69,377,695.4
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	74,534,000.0	74,534,000.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,203,186,700.0	4,124,217,324.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,203,186,700.0	4,085,871,330.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,203,186,700.0	4,085,871,330.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,203,186,700.0	4,085,871,330.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	38,345,994.5
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	38,345,994.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		376,850,523.83
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО		
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	83	79
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	52	49
	Үйлчлэх	30	29

Гурав. Аудитын илрүүлэлт:

Худалдан авах ажиллагааны хуулийн хэрэгжилт

Тайлант онд тус байгууллага нь төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 4 удаа худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан байна.

Хүснэгт 3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Тендер шалгаруулалт зарласан огноо	Тендер шалгаруулалтын нэр	ХАА-ны мөрдөх журам	Төсөвт өртөг	Шалгарсан оролцогчийн нэр	Гэрээ байгуулсан дүн
1	2025-03-25	Мах, махан бүтээгдэхүүн	НТШ	124,000.0	Өрнөх Чойр ХХК	112,456.0
	2025-03-25	Хуурай хүнс, хүнсний ногоо	НТШ	105,000.0	-	-
2	2025-03-25	Оюутан суралцагчдын үйлдвэр сургалтын дадлагын материал	НТШ	130,000.0	Баасандэлгэр Мягмарбаатар	115,774.5
3	2025-08-28	Хуурай хүнс, хүнсний ногоо	НТШ	105,000.0	-	-
4	2025-08-28	Түлш шатахуун	НТШ	60,000.0	-	-
Нийт				524,000.0		228,230.5

Хүснэгтээс харахад давхардсан тоогоор 4 удаа 524,000.0 мянган төгрөгийн тендер шалгаруулалтыг зарлаж 254,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 барааг 228,230.5 мянган төгрөгөөр нийлүүлэх нийлүүлэгчийг амжилттай сонгон шалгаруулсан бол 3 тендерт оролцогч шалгараагүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, 2022 оны А/89 дүгээр тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг баталсан бөгөөд уг чиглэл, зааврын дагуу санхүүгийн тайлангийн аудитаар шалгагдагч байгууллагад хамааралтай 29 шалгуур үзүүлэлтээр горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

•Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 , 15.1.4 -т заасныг зөрчиж Сургууль сурталчлах танилцуулга видео контент 1,500.0 мянган төгрөгөөр бэлтгэсэн тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

•Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 , 15.1.5. -т заасныг зөрчиж төсвийн хөрөнгөөр 1,019.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлийг худалдан авсан тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

•Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6 -т заасныг зөрчиж 3 дугаар улирлын байдлаар 69 албан хаагчид 288 хоногийн цалинтай чөлөөг хавтгайруулан олгож 18,474.8 мянган төгрөгийг арвилан хэмнэлт, үр ашиггүй зарцуулсан тул зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

•Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.8 -т заасныг зөрчиж байгууллагын төсвөөс 483.0 мянган төгрөгөөр биеийн тамирын тэмцээн зохион байгуулсан тул төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байна

Санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт **216,856.6** мянган төгрөгийн алдаа илэрснээс **191,119.9** мянган төгрөгийн алдааг завсрын аудитаар, **25,736.7** мянган төгрөгийн алдааг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар тус тус залруулсан.

Залруулсан алдаа:

1. Мөнгөн гүйлгээний тайланд 1,296.7 мянган төгрөгийн НДШ-ийн, 3,453.0 мянган төгрөгийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн зардлыг дансны хуулгаас дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх, 14 дүгээр зүйлийн 14.4.6 дахь заалт, УСНББОУС- Онолын үзэл баримтлал 3.10 Үнэн зөв илэрхийлэх, 3.17 Ойлгомжтой байх, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй.

2. Санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 9,414.3 мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, УСНББОУС- Онолын үзэл баримтлал 3.10 Үнэн зөв илэрхийлэх, 3.17 Ойлгомжтой байх, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй.

3. ХХОАТ-ын илүү төлөлт 3,358.2 мянган төгрөгийг авлага үүсгэж бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт, УСНББОУС- Онолын үзэл баримтлал 3.10 Үнэн зөв илэрхийлэх, 3.17 Ойлгомжтой байх, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.

4. ХХОАТ-ын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т заасны дагуу 7,745.9 мянган төгрөгийн хөнгөлөлтийг татварын тайланд тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэхь заалт, УСНББОУС- Онолын үзэл баримтлал 3.10 Үнэн зөв илэрхийлэх, 3.17 Ойлгомжтой байх, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөл зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

5. Нийгмийн даатгалын газартай тооцоо нийлсэн актаар баталгаажсан 468.4 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт, УСНББОУС- Онолын үзэл баримтлал 3.10 Үнэн зөв илэрхийлэх, 3.17 Ойлгомжтой байх, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Аудитаар нийт 5,614.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 371.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 4,043.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1,200.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж, сахилгын хариуцлага тооцуулах 1 албан шаардлага өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Томилолтоор ажилласан албан хаагчдад 371.0 мянган төгрөгийн хоол, унааны олговрыг давхардуулж олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4 "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Сангийн сайдын 2025 оны 03 дугаар тушаалаар батлагдсан Зардлын эдийн засгийн ангилал 210103 "Хоол, унааны хөнгөлөлт", Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар" 210103 "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журамд заасны дагуу ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн унааны зардлын 50 хувийг олгох, мөн өдрийн хоолны хөнгөлөлтийг олгох зардлыг энэ ангилалд бүртгэнэ.", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2 "Албан томилолтоор ажиллах

үеийн нөхөх төлбөр дараахь зардлаас бүрдэнэ", 2.2.3 "хоолны зардал", санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулж олгосон хоолны хөнгөлөлт 371.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Ажлын удирдамж, төлөвлөгөө, тайлангүй албан ажлаар явсан эсэх нь тодорхойгүй анхан шатны баримтын бүрдэл хангаагүй баримтыг үндэслэн 854.3 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулахгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;" заалт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Шатахууны зардлыг олгохдоо ажил үүрэгтэй хамааралтай болохыг нотолсон удирдамж, төлөвлөгөө, тайланд үндэслэх, зөрчлийг давтан гаргахгүй байх, бүртгэл тайлагналыг сайжруулах албан шаардлага өгөв.

5.2.2 Давхардсан тоогоор 15 албан хаагчид эмчийн магадлагаатай үед цалин хөлсийг ажилласнаар тооцож 3,188.7 мянган төгрөгийг олгосон.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6 дахь "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.", Хөдөлмөрийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь "Хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ дараах шаардлагыг хангасан байна.", 12.2.2 дахь "хөдөлмөр, нийгмийн хамгааллын хууль тогтоомжоос бусад хууль тогтоомжтой зөрчилдөөгүй байх;" заалт, УСНББОУС "Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал", нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Уг зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөв.

5.2.3 Тус байгууллагын нягтлан бодогч Л.Сарангуа нь 2025 оны санхүүгийн тайланд татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог үнэн зөв хийгээгүй, завсрын аудитаар өгсөн алдаа залруулах зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан, Төрийн хэмнэлтийн хуулиар хориглосон үйл ажиллагаанд төсвийн хөрөнгийг зарцуулсан, хариуцсан ажил үүрэгтээ хайнга хандаж материаллаг өндөр дүн бүхий залруулгыг санхүүгийн тайланд хийсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.", 15.2 дахь "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна.", 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон хууль тогтоомжид харшилсан шийдвэрийг биелүүлэхээс татгалзах;", 20.2.3 дахь "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;", 20.2.4 дэх "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх;", 15.1.5 дахь "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл

худалдан авах;”, 15.1.8 дахь “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтөлж тайлагнаагүй, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн сахилга бат хариуцлага хангалтгүй, алдаа, зөрчлийг давтан гаргасан байгууллагын ахлах нягтлан бодогч Л.Сарангуад сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Бичиг хэргийн материалын тайланд 1,200.0 мянган төгрөгийн сканнерыг орлого, зардлаар бүртгэж тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:", 14.4.2 дахь "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" заалт, УСНББОУС-Онолын үзэл баримтлал 3.10 Үнэн зөв илэрхийлэх, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Зардлаар бүртгэсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэн, эд хариуцагчид хүлээлгэн өгөх зөвлөмж өгөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор, албан шаардлага, төлбөрийн актыг хэрэгжүүлэх хугацаанд нь, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг тайланг гардаж авснаас 30 хоногийн дотор тус тус Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ПТК	9	216.8	8	207.4	1	9.4	9	216.8				
Дүн	9	216.8	8	207.4	1	9.4	9	216.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл:

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ПТК	5	5.6	1	0.4	2	4.0	1	1.2
Дүн	5	5.6	1	0.4	2	4.0	1	1.2

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

ПТК	2	21.5	1	0.5	1	21.0		
Дүн	2	21.5	1	0.5	1	21.0		
Дүн								
Нийт дүн	2	21.5	1	0.5	1	21.0		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			